

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04-р сарын 18

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ байгууллагын хурлын танхимд ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулсанаар 10.20 цагт 40092 хувьцаа эзэмшдэг гишүүд ирснээр 98,6 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын хараат бус гишүүд оролцов.

ХЭХ-ыг ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-с гаргасан тогтоол, хурлын дэгийг танилцуулав. Дэгийг 100 хувь батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчээр Г.Буд, Л.Шагдаррагчаа, Ш.Ариунбат нарыг томилов. Хуралд оролцогсод бүх тайлантай танилцсаны дараа асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тогтов.

Барилга ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ын тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

Үүний дараа Барилга ХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат байгууллагын тайлан, оны үйл ажиллаганы үр дүн болон ирэх оны үйл ажиллаганы чиглэлийн талаархи тайлангаа уншиж танилцуулав. Тайланг хавсаргасан болно.

Ерөнхий няглан бодогч Э.Батсүх 2016 оны санхүүгийн тайлан, Дөлгөөн Хайрхан Уул Аудитын дүгнэлтийг болон аудитороос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг уншиж танилцуулав. Зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг дурьдсан бөгөөд санхүүгийн тайланг хавсаргав.

11.00-д хараат бус гишүүн Д.Дашжамц нэмэгдэж ирэв.

Бүх тайлангууд танилцуулагдсаны дараа асуулт хариулт руу шилжив:

Ш.Үнэнбат: Тооцоо нийлсэн акт хийхгүйгээр яаж тайлан гаргаад яваад байна. Аудитын зөвлөмж дээр бас дурдсан байна. Шинээр баригдсан оффисын барилгын талаар тодруулга асуув. Ямар сувгуудаар мэдээлэл хүргэж байгаа вэ? Хэдэн ажлын байр бий болгож байгаа вэ? Хуучин оффисоо яах гэж байгаа вэ?

Э.Батсүх: Программ дээр нэр, данс давхардаж бүртгэгдсэнтэй холбоотойгоор өглөг, авлагын данснууд сөрөг үлдэгдэлтэй байгаад байгаа. Харилцагч нэг бүрийг программ дээр давхардуулж бүртгэхгүй байвал дээрхи өглөг, авлагын дансууд сөрөг үлдэгдэлтэй, харилцагч бүрээр хаагдаагүй байх асуудал гарахгүй. Цаашид удитын компаниас өгсөн зөвлөмжийн дагуу тооцоо нийлсэн акт үйлдэж, алдааг давтахгүйгээр ажиллах болно.

Ш.Эрдэнэбат: Шинээр ашиглалтанд орж байгаа оффисын барилгын мэдээллийг интернетээр хүргэж байгаа бөгөөд одоогоор 12 орчим ажлын байр бий болгохоор төлөвлөж байна.

Ш.Үнэнбат: Надад санал байна. Санхүүгийн тайлангаа янзлаад ТУЗ-д танилцуулаарай. Шинээр ашиглалтанд орох байранд хөдөө орон нутгийн хүмүүс авах дэмий болон дан

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

эмэгтэй хүн авах нь дэмий байх. Мөн Авто худалдааны цогцолборын 2 барилгын 1-ийг нь барьж суурийн цутгах нь зүйтэй.

Б.Энхболд: Санхүү дээр өглөг авлагаа сайн холбож өгөх. Он дамжсан төлбөр тооцооны нэг учрын сайн олчвол зүгээр байхаа. Шинэ оффист оруулах түрээслэгчдээ анхаарах. Мөн авто худалдааны цогцолбор дээр 1 барилгыг нь барих нь зөв.

Б.Батцагаан: Чанар, хяналтын албатай болмоор байна. энэ тал дээр анхаарч шийдвэр гаргах

Г.Буд: Шинэ баригдаж байгаа оффисын байрандаа тогтсон гэр бүл байх нь зүйтэй. Тогтвортой түрээслэгчтэй байхгүй бол урсгал зардал их гардаг. Орчны тохижилт ямар байгаа вэ?

Ж.Жадамбаа: Эрсдлүүдийг сайн тооцож байж шийдвэр гаргах хэрэгтэй.

Д.Дашжамц: Үйлчилгээний бизнес, ижил төрлийн бизнес эрхэлж буй хүмүүс юун дээр алдсан байна. Тийм алдааг гаргахгүйн тулд анхаарч ажиллах хэрэгтэй.

Л.Шагдаррагчаа: Их зүйтэй саналууд хэлж байна. Цаашид анхааръя.

Саналуудын дараа гарах тогтоолын төслүүдэд санал хурааж тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав. Тогтоол 3, 4-ийг 100 %-ийн санал нэгтэй дэмжив. Тогтоол 5 дээр тусгасан Оффис үйлчилгээний төвийн барилгын хөрөнгө оруулалтад 1.5 тэрбум төгрөг бага байна гэдэг Ш.Эрдэнэбатын саналыг харгалзан үзэж хийсэн гүйцэтгэлээр нь тооцохоор тогтов. Тогтоол 6-г 100 %-ийн санал нэгтэй батлав.

Өөр санал гарсангүй, хурал 12.30 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.АРИУНТУЯА